



ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

2018.04.02-04.06

ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛ

АНУ: Энэ долоо хоногт АНУ-ын хувьцааны индексүүд ихээр хэлбэлзэн бага зэрэг унасан байна. Өргөн хэрэглээний бараа болон эрчим хүчний салбарын хувьцаануудын ханш өсөн, эрүүл мэнд, үйлдвэрлэл болон технологийн салбарын хувьцаануудын ханш унав.

АНУ-ын шуудан хүргэлтийн үйлчилгээ Amazon.com компаниас болж алдагдал хүлээж байгаа хэмээн тус улсын Ерөнхийлөгч үзсэн нь уг компанийн хувьцааны ханш буурахад нөлөөлжээ. Мөн урсгал хөгжмийн "Spotify" компани IPO гаргасан байна.

Мөн энэ долоо хоногт худалдааны дайн үүсэх эрсдэл нэмэгдсэн байна. Даваа гаригт БНХАУ нь АНУ-ын хөдөө аж ахуйн 130 орчим бүтээгдэхүүнд 3 тэрбум ам.долларын шинэ тариф тогтооно гэсэн бол АНУ Мягмар гаригт хариу барин Хятад улсын 1,300 орчим бүтээгдэхүүнд 50 тэрбум ам.доллартай тэнцэх тариф ногдуулна хэмээн мэдэгдсэн. Улмаар Лхагва гаригт Хятад улс АНУ-аас импортоор орж ирдэг шар буурцаг, машин, нисэх онгоц зэрэг бүтээгдэхүүнд 50 тэрбум ам.доллартай тэнцэх хэмжээний тарифт ногдуулна гэжээ.

АНУ-ын Хөдөлмөрийн яамны сар бүрийн тайланд цалингийн өсөлт төсөөлснөөс бага хэмжээтэй гарчээ.

Европ: Европын орнуудын компаниудын хувьцааны ханш мөн л худалдааны дайны асуудалтай холбоотойгоор тогтворгүй байлаа.

Зарим макро эдийн засгийн үзүүлэлтүүд Европын эдийн засгийн байдал сайжирч байгааг илтгэж байна. Европын статистикийн байгууллагын тооцоогоор Европын 19 орны ажилгүйдлийн түвшин 2008 оны 12-р сараас хойш хамгийн доод түвшинд хүрчээ. Харин инфляцийн түвшин зорилтод 2%-аас бага байв. 2-р сард Герман улсын дотоод эрэлт унасан нь тус улсын аж үйлдвэрлэл 1,6%-аар буурахад нөлөөлжээ.

Япон: Японы компаниудын хувьцааны ханш энэ долоо хоногт өсөлттэй хаагдлаа. Иений ханш бага зэрэг сулран Баасан гарагт ам. долларын эсрэг 107.11 нэгж хүрчээ.

Олон улсын валютын сангийн тооцоогоор 2016 оны сүүлээс эхлэн дэлхийн улс орнууд иены валютын нөөцөө улам нэмсээр байна. БНХАУ болон АНУ-ын хоорондын байдал хурцдах тусам улс орнууд тогтвортой валютын нөөцөө нэмэгдүүлж байгаа аж.

Эх сурвалж: Reuters, Troweprice

Олон улсын индексүүд

Индекс	Улс	Хаалт	Өөрчлөлт
MSE TOP 20	Монгол	20,055.70	-4.60% ▼
Dow Jones	АНУ	23,932.76	-0.71% ▼
S&P 500	АНУ	2,604.47	-1.38% ▼
Nasdaq	АНУ	6,915.11	-2.10% ▼
S&P/TSX	Канад	15,207.41	-1.04% ▼
FTSE 100	Их Британи	7,183.64	1.80% ▲
S&P/ASX 200	Австрали	5,788.70	0.51% ▲
Nikkei 225	Япон	21,567.52	0.53% ▲
Hang Seng	Хонг Конг	29,844.94	-0.83% ▼

Бондын өгөөж

Бонд	Валют	Купон	Үнэ
Mongol 2024 (Хуралдай)	USD	8.7%	112.98
Mongol 2023 (Гэрэгэ)	USD	5.6%	99.36
Mongol 2022 (Чингис)	USD	5.1%	98.36
Mongol 2021 (Мазаалай)	USD	10.8%	115.51
Mongol CNY (Димсам)	CNY	7.5%	100.38
DBM' 23 (Самурай)	JPY	1.5%	104.80
TDBM' 2020	USD	9.3%	107.63

Зах зээлийн хүү

Хүү	Хаалт	Үөү
Libor 1M	1.897	0.01 ▲
Libor 3M	2.337	0.03 ▲
Libor 6M	2.472	0.02 ▲
Libor 1YR	2.708	0.05 ▲
US 6M Bond	1.880	-0.03 ▼
US 2YR Bond	2.282	0.00 ▲
US 3YR Bond	2.416	0.01 ▲
US 5YR Bond	2.603	0.01 ▲
US 10YR Bond	2.788	0.02 ▲

Валютын ханш /төг/

Валют	2018.04.06	Өөрчлөлт
USD	2,391.58	-0.05% ▼
CNY	379.30	-0.55% ▼
EUR	2,924.18	-0.82% ▼
RUB	41.35	-0.93% ▼
KRW	2.24	-0.44% ▼
JPY	22.27	-1.15% ▼

Түүхий эдийн үнэ

Түүхий эд	Хаалт /USD/	Өөрчлөлт
Алт /spot/	1,330.93	0.41% ▲
Мөнгө /spot/	16.40	0.18% ▲
Эс	305.20	0.88% ▲
Нүүрс	93.00	1.97% ▲
WTI газрын тос	62.25	-4.14% ▼
Brent газрын тос	67.35	-2.87% ▼
Байгалийн хий	2.68	-1.83% ▼

Макро эдийн засгийн үзүүлэлтүүд

Үзүүлэлт	Хугацаа	Хэмжээ
Инфляций түвшин	2018.11	6.90%
Бодлогын хүү	2018.11	10.00%
Банк хоорондын зах зээлийн хүү	2018.11	11.00%
Хадгаламжийн дундаж хүү /төгрөг/	2018.11	12.90%
Хадгаламжийн дундаж хүү /валют/	2018.11	5.20%
Зээлийн дундаж хүү /төгрөг/	2018.11	19.10%
Зээлийн дундаж хүү /валют/	2018.11	11.50%

Эх сурвалж: Үндэсний статистикий хороо, Монголбанк, Bloomberg

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АРИЛЖАА

Энэ 7 хоногт Монголын хөрөнгийн бирж дээр 60 компанийн 1,737.1 сая төгрөгийн 5,160,170 ширхэг хувьцаа арилжигдав.


“Дархан гурил тэжээл” /DAR/ компанийн хувьцаа 32.25%-аар буюу хамгийн ихээр өсч 684.39 төгрөгт хүрч хаагдсан бол “Таван Толгой” /TTL/ компанийн хувьцаа 24.44%-аар буурч 8,750 төгрөгт хүрч хаагдлаа. Мөн тайлант долоо хоногт ЗГҮЦ-ны анхдагч зах зээлд арилжаа хийгдээгүй.

ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээл дээр нийт 3 удаагийн хэлцлээр 5,240 ширхэг үнэт цаас 519.9 сая төгрөгөөр арилжаалагдлаа.

Харин компанийн бондын хувьд хоёрдогч зах зээл дээр энэ долоо хоногт 100 сая төгрөгийн арилжаа хийгджээ.


4-р сарын 6-ны өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 2,404.4 тэрбум төгрөгт хүрсэн бол MSE TOP-20 Индекс 20,055.7 нэгж болж өмнөх 7 хоногийн үзүүлэлтээс 4.6%-аар буурсан байна.

MSE Индекс



Эх сурвалж: MSE

Арилжааны үнийн дүн /7 хоногээр/



Эх сурвалж: MSE

Зах зээлийн хураангуй

Хураангуй	Үнийн дүн /сая төг/
Арилжигдсан үнийн дүн	2,357.0
Зах зээлийн үнэлгээ	2,404,473.6

Зах зээлийн индекс

Индекс	Хаалт	Өөрчлөлт
MSE Top 20	20,055.70	-4.60% ▼
MSE I индекс	9,291.99	-11.10% ▼
MSE II индекс	10,186.77	0.71% ▲

Идэвхтэй арилжигдсан хувьцаа

Компани	Ширхэг	Үнийн дүн /төг/
Дархан нэхий	40,604	743,053,000
Таван Толгой	44,566	452,255,335
ЛэндМН ББСБ	3,582,654	156,165,050
Би Ди Сек	89,641	107,556,524
АПУ	144,183	90,041,162

Өсөлттэй хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Дархан гурил тэжээл	684.39	32.25% ▲
Силк нэт	734.57	32.25% ▲
Сонсголон бармат	1,086.00	32.23% ▲
Мон Наб	4,025.00	15.00% ▲
Эрдэнэт зандан	1,976.00	14.95% ▲

Бууралттай хувьцаа

Компани	Хаалт /төг/	Өөрчлөлт
Таван Толгой	8,750.00	-24.44% ▼
Улаансан	900.00	-18.18% ▼
Нэхээсгүй эдлэл	2,125.00	-14.97% ▼
Сор	1,235.00	-14.83% ▼
Ногоон хөгжил үндэсний нэгдэл	130.00	-10.34% ▼

Арилжаанд идэвхтэй оролцсон үнэт цаасны компаниуд

Компани	Арилжааны үнийн дүн /төг/
Дэлгэрхангай секьюритиз	1,493,270,725
БиДиСек	398,169,601
Ард капитал групп	214,330,576
Ти Ди Би Капитал	170,337,544
Бумбат-Алтай	147,191,893

Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 5 компани

Компани	Хаалт /төг/	ЗЗҮ /сая.төг/
АПУ	612.82	652,151
Таван толгой	8,750.00	460,820
МИК	11,290.00	233,808
Говь	23,000.00	179,425
Сүү	230.00	79,120

ЗГҮЦ-НЫ ХОЁРДОГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖАА

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
1	ZBEG-BD-22/05/20-A0248-15.87	210	21,310,800	101,480	101,480	156	15.870
2	ZBEG-BD-25/04/20-A0236-16.993	30	3,101,700	103,390	103,390	156	16.993
3	ZBEG-BD-24/04/18-A0235-0	5,000	495,500,000	99,100	99,100	52	16.081

КОМПАНИЙН БОНДЫН ХОЁРДОГЧ ЗАХ ЗЭЭЛИЙН АРИЛЖАА

№	Үнэт цаасны нэр	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
1	SUUB-BD-29/06/18-C0006-17.5	1,000	100,000,000	100,000	100,000	52	17.500

НОГДОЛ АШИГ ЗАРЛАСАН ХУВЬЦААТ КОМПАНИУД

№	Симбол	Компанийн нэр	Нийт ногдол ашиг /сая төг/	Нэгж хувьцаанд ногдох ашиг /төг/	Шийдвэр огноо	Бүртгэлийн өдөр	Хуваарилах өдөр
1	TTL	Таван Толгой	ХЭХ-аар тогтооно		2018.03.16	2018.04.03	N/A
2	DSS	Дархан Сэлэнгийн Цахилгаан Түгээх Сүлжээ ХК	587.7	56.6	2018.03.07	2018.03.27	2018.07.02-с
3	AEL	Анд-Энерги ХК	13.3	0.5	2018.02.24	2018.03.16	N/A
4	SUL	Жуулчин дүти фрии ХК	653.6	10,000.0	2018.02.23	2018.04.11	2018.05.01-с
5	SUU	Сүү ХК	1,032.0	3.0	2018.02.14	2018.04.05	2018.12.31-ний дотор
6	GTL	Гутал ХК	2,055.7	1,270.0	2018.02.19	2018.03.18	2018.07.06-с
7	BNG	Баянгол Зочид буудал ХК	150.2	355.0	2018.02.19	2018.04.06	2018.09.01-с
8	APU	АПУ ХК	10,641.8	10.0	2018.02.19	2018.03.29	2018.06.01-ний дотор
9	BTG	Баянтээг ХК	25.3	100.0	2018.02.19	2018.03.12	2018.06.01-ний дотор
10	MIE	Материалимпекс ХК	13.7	10.0	2018.02.19	2018.03.26	2018.12.31-ний дотор
11	MNP	Монгол шуудан ХК	367.2	3.7	2018.02.13	2018.04.13	2018.05.01-с
12	MMX	Махимпекс ХК	380.1	100.0	2018.02.13	2018.04.05	2018.10.01-с
13	TCK	Талх чихэр ХК	174.0	170.0	2018.02.12	2018.04.06	2018.07.01-с
14	ADL	Адуун чулуун ХК	409.6	130.0	2018.01.24	2018.03.01	N/A
15	UBH	Улаанбаатар хивс ХК	40.4	100.0	2018.02.05	2018.02.26	2018.05.01-ний дотор
16	ТАН	Тахь-ко ХК	128.5	108.0	2018.02.05	2018.03.30	2018.05.01-ний дотор
17	GOV	Говь ХК	1,716.2	220.0	2018.02.02	2018.03.27	2018.04.24-с
18	HRM	Гермес Центр ХК	392.7	5.0	2018.01.24	2018.02.15	2018.03.06-с

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРАЛ ЗАРЛАСАН ХУВЬЦААТ КОМПАНИУД

№	Симбол	Компанийн нэр	Бүртгэл	Хуралдах өдөр		№	Симбол	Компанийн нэр	Бүртгэл	Хуралдах өдөр	
1	DAZ	Дорнод авто зам	2018.03.12	2018.04.09	15:00	13	HTS	Хөтөлийн цемент шохой	2018.03.28	2018.04.16	10:00
2	GTL	Гутал	2018.03.18	2018.04.09	15:00	14	HUV	Хөвсгөл геологи	2018.03.29	2018.04.17	10:00
3	HUZ	Хөвсгөл усан зам	2018.02.26	2018.04.09	-	15	GOV	Говь	2018.03.27	2018.04.17	14:00
4	UBH	Улаанбаатар хивс	2018.02.26	2018.04.10	11:00	16	HVL	Хөвсгөл	2018.03.28	2018.04.17	14:00
5	OLL	Оллоо	2018.03.19	2018.04.10	14:00	17	HNS	Хөвсгөл хүнс	2018.03.28	2018.04.17	17:00
6	ALI	Стандарт Ноос	2018.02.26	2018.04.10	15:00	18	TGS	Номин Хишиг	2018.03.29	2018.04.18	10:00
7	HRL	Хэрлэн хивс	2018.03.19	2018.04.10	-	19	SOR	Сор	2018.03.28	2018.04.18	10:00
8	ETR	Э-Транс ложистикс	2018.03.23	2018.04.11	10:00	20	ARH	Сэлэнгэ Ар Хөвч	2018.03.30	2018.04.18	14:00
9	HUN	Увс хүнс	2018.03.23	2018.04.13	9:00	21	HHN	Хархорин	2018.03.30	2018.04.18	14:00
10	BRC	Барилга Корпораци	2018.03.16	2018.04.14	10:00	22	MIE	Материалимпекс	2018.03.26	2018.04.20	10:30
11	DBL	Даваанбулаг	2018.03.24	2018.04.14	14:00	23	TAV	Тав	2018.03.28	2018.04.20	11:00
12	TEX	Техник импорт	2018.03.28	2018.04.16	15:00						

№	Сим бол	Компанийн нэр	Бүртгэл	Хуралдах өдөр		№	Сим бол	Компанийн нэр	Бүртгэл	Хуралдах өдөр	
24	APU	АПУ ХК	2018.03.29	2018.04.20	15:00	70	JLT	Ногоон хөгжил үндэсний нэгдэл	2018.03.22	2018.04.28	14:00
25	NOG	Ачит Алкабы	2018.03.27	2018.04.20	15:00	71	TUS	Түшиг Уул	2018.03.29	2018.04.28	14:00
26	DSS	Дархан Сэлэнгийн цахилгаан түгээх сүлжээ	2018.03.27	2018.04.20	16:00	72	MOG	Монгео	2018.04.09	2018.04.29	9:00
27	HSG	Хөсөг трейд	2018.03.23	2018.04.21	12:00	73	HCH	Е-Моние	2018.04.08	2018.04.29	11:00
28	AEL	Анд-Энерги	2018.03.16	2018.04.21	12:00	74	HBZ	Хүннү менежмен	2018.04.08	2018.04.29	11:00
29	CHR	Увс Чацаргана	2018.03.23	2018.04.22	11:00	75	DAR	Дархан гурил тэжээл	2018.04.10	2018.04.29	13:00
30	BNB	Баялаг Налайх	2018.03.30	2018.04.22	15:00	76	DOT	Дорнод тээвэр	2018.04.08	2018.04.29	14:00
31	BDS	Би Ди Сек	2018.04.02	2018.04.23	10:00	77	TVT	Хар тарвагатай	2018.04.09	2018.04.29	15:00
32	SDT	Хот девелопмент	2018.04.03	2018.04.23	10:00	78	HSR	Хасу-Мандал	2018.03.23	2018.04.29	15:00
33	BEU	Бэрх Уул	2018.04.03	2018.04.23	12:00	79	SUL	Жуулчин дюти фрии	2018.04.11	2018.04.30	10:00
34	MNS	Монноос	2018.03.31	2018.04.23	15:00	80	DMA	Дэвшил Мандал	2018.04.06	2018.04.30	9:00
35	UYN	Монгол савхи	2018.04.05	2018.04.24	10:00	81	NXE	Нэхээсгүй эдлэл	2018.04.06	2018.04.30	9:00
36	JGV	Жуулчин говь	2018.04.05	2018.04.24	13:00	82	ALA	Алтайн Нэгдэл	2018.03.30	2018.04.30	10:00
37	MNG	Мандал говь импекс	2018.04.05	2018.04.24	15:00	83	BAZ	Люкс зананду групп	2018.04.06	2018.04.30	10:00
38	BHG	Бөхөг	2018.03.23	2018.04.25	10:00	84	MIK	МИК Холдинг	2018.04.11	2018.04.30	10:00
39	TAN	Тахь-ко	2018.03.30	2018.04.25	10:00	85	MNP	Монгол шуудан	2018.04.13	2018.04.30	10:00
40	BBD	Стандарт проперти групп	2018.04.10	2018.04.25	11:00	86	TMZ	Төмрийн завод	2018.04.09	2018.04.30	10:00
41	BUK	УБ-БҮК	2018.04.03	2018.04.25	11:00	87	NRS	Шинэст	2018.04.10	2018.04.30	10:00
42	BDL	Могойн гол	2018.04.04	2018.04.25	12:00	88	BAN	Багануур	2018.04.13	2018.04.30	11:00
43	EER	Ариг гал	2018.04.02	2018.04.25	17:00	89	GTJ	Булган гурил тэжээл	2018.04.06	2018.04.30	11:00
44	HJL	Орхон хөгжил	2018.04.03	2018.04.25	-	90	BLC	Бүтээлч үйлс	2018.04.05	2018.04.30	11:00
45	MMX	Махимпекс	2018.04.05	2018.04.26	14:00	91	JGL	Говийн өндөр	2018.04.09	2018.04.30	11:00
46	TTL	Таван Толгой	2018.04.03	2018.04.26	14:00	92	MCH	Монголын цахилгаан холбоо	2018.04.06	2018.04.30	11:00
47	SHG	Шарын гол	2018.04.02	2018.04.26	15:30	93	RMC	Ремикон	2018.04.12	2018.04.30	11:00
48	BNG	Баянго зочид буудал	2018.04.06	2018.04.26	16:00	94	SOH	Уужим Хангай	2018.04.12	2018.04.30	11:00
49	MBG	Мон-Ит Булигаар	2018.04.05	2018.04.27	9:00	95	EAZ	Эрдэнэт авто зам	2018.04.06	2018.04.30	11:00
50	JTB	Женко Тур Бюро	2018.04.04	2018.04.27	10:00	96	BAJ	Баялаг-Сүмбэр	2018.04.12	2018.05.01	11:00
51	UID	Улсын их дэлгүүр	2018.03.30	2018.04.27	10:00	97	NKT	Нако Түлш	2018.04.03	2018.04.30	12:00
52	BUN	Булган ундрага	2018.04.06	2018.04.27	11:00	98	АНН	Хорин хоёрдугаар бааз	2018.03.23	2018.04.30	13:00
53	ERS	Монгол алт	2018.04.05	2018.04.27	11:00	99	HZB	Ган хэрлэн	2018.04.06	2018.04.30	14:00
54	MNH	Монгол Нэхмэл	2018.03.30	2018.04.27	11:00	100	INT	Ингэттолгой	2018.04.09	2018.04.30	14:00
55	MIB	Монинжбар	2018.03.20	2018.04.27	11:00	101	MSH	Монгол шилтгээн	2018.04.06	2018.04.30	14:00
56	CHE	Хорго Хайрхан	2018.04.06	2018.04.27	11:00	102	HBO	Хай би ойл	2018.04.10	2018.04.30	14:00
57	SUN	Евроази капитал холдинг	2018.03.20	2018.04.27	12:00	103	HGN	Хөх ган	2018.04.06	2018.04.30	14:00
58	BOE	Эрчим баян өлгий	2018.04.05	2018.04.27	12:00	104	SHV	Шивээ овоо	2018.04.05	2018.04.30	14:00
59	ALD	Азык	2018.03.28	2018.04.27	14:00	105	JRG	Эвлэл	2018.04.09	2018.04.30	14:00
60	ATR	Атар-Өргөө	2018.04.10	2018.04.27	14:00	106	TAS	Эрдэнэт хүнс	2018.03.31	2018.04.30	14:00
61	DZG	Дархан зочид буудал	2018.03.28	2018.04.27	14:00	107	ITLS	Айтүүлс	2018.04.06	2018.04.30	15:00
62	GFG	Силк нэт	2018.03.20	2018.04.27	14:00	108	GUR	Гурил	2018.04.07	2018.04.30	15:00
63	TCK	Талх Чихэр	2018.04.06	2018.04.27	14:00	109	SUU	Сүү	2018.04.05	2018.04.30	15:00
64	TEE	Тээвэр дархан	2018.04.05	2018.04.27	14:00	110	MDR	Фронттиер лэнд групп	2018.04.06	2018.04.30	15:00
65	DHU	Дархан Хүнс	2018.04.05	2018.04.27	14:00	111	HAM	Монголын хөгжил үндэсний нэгдэл	2018.04.09	2018.04.30	17:00
66	MRX	Мерекс	2018.04.07	2018.04.28	10:00	112	BSKY	Блюскай секьюритиз	2018.03.30	2018.04.30	18:00
67	ECV	Эрээнцав	2018.04.09	2018.04.28	11:00	113	ONH	Өндөрхаан	2018.04.12	2018.04.30	13:00
68	AMT	Хар хорум пропертийс	2018.04.09	2018.04.28	12:00	114	HTS	Хөтөлийн цемент шохой	2018.04.17	2018.05.07	10:00
69	MBG	Жинст-Увс	2018.04.12	2018.04.28	14:00	115	LND	ЛендМН ББСБ	2018.04.11	2018.05.10	18:00

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

“Хөвсгөл Алтан Дуулга” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хувьцааг эргүүлэн авахыг шаардах эрх үүслээ

Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй “Хөвсгөл Алтан Дуулга” ХК нь 2018 оны 4 дүгээр сарын 2-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаараа “Компани нэмж хувьцаа гарган олон нийтэд санал болгох, Төлөөлөн удирдах зөвлөлд зарим бүрэн эрх олгох тухай” гэсэн 2 дугаартай шийдвэрээр Компанийн тухай хуулийн 87.1.2-т заасан их хэмжээний хэлцэл буюу 4,405,600 ширхэг энгийн хувьцаа нэмж гарган, олон нийтэд санал болгохоор шийдвэрлэв. Энэхүү шийдвэр гаргах санал хураалтад оролцоогүй, эсхүл эсрэг саналтай байсан хувьцаа эзэмшигчид Компанийн тухай хуулийн 53, 54 дүгээр зүйлд заасны дагуу өөрийн эзэмшлийн хувьцааг эргүүлэн худалдаж авахыг компаниас шаардах эрх үүссэн болно.

Иймд “Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн шаардах эрх нь үүссэн хувьцаа эзэмшигчид уг эрхээ хэрэгжүүлэх хүсэлтэй бол “Хөвсгөл алтан дуулга” ХК болон андеррайтер “Бумбат-Алтай ҮЦК” ХХК-д хандана уу.

Хувьцаагаа эргүүлэн худалдан авахыг шаардах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийн огноо: 2018 оны 4-р сарын 02-ны өдөр

Хувьцаагаа эргүүлэн худалдан авахыг шаардах эрх дуусах огноо: 2018 оны 5-р сарын 17-ны өдрийг хүртэл

Эх сурвалж: MSE.mn



СЗХ: Татан буугдсан брокеруудын харилцагчдын дийлэнхийг “Бумбат Алтай ҮЦК” ХХК-д шилжүүлнэ

Татан буугдсан брокер, дилерийн найман компанийн харилцагчдыг шилжүүлэхээр болсон талаар Санхүүгийн зохицуулах хороо мэдээллээ. “Ай трейд ҮЦК” ХХК, “Эм Даблю Ти Эс ҮЦК” ХХК, “Финанс линк групп ҮЦК” ХХК, “Говийн ноён нуруу ҮЦК” ХХК, “Превалент ҮЦК” ХХК, “Би Би Эс Эс ҮЦК” ХХК-ийн зэрэг үнэт цаасны найман компанийн нийт 31 мянга гаруй харилцагчийн дийлэнхийг “Бумбат Алтай ҮЦК” ХХК-д шилжүүлэхээр болсон байна. Харин үлдсэн мянга орчим харилцагчийг “Би Ди Сек ҮЦК” ХК-д болон “Өндөрхаан инвест ҮЦК” ХХК-д шилжүүлэх ажээ. Ингэснээр 31 мянга гаруй харилцагч нэмэлт төлбөр, зардалгүйгээр үнэт цаасны дансаа үргэлжлүүлэн эзэмших боломжтой болж байна. Ийнхүү харилцагчийнхаа тоог 30 орчим мянгаар нэмэгдүүлж байгаа “Бумбат алтай” компани 2017 онд 4.3 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллажээ. Энэ нь өмнөх оноос 4.3 дахин өссөн үзүүлэлт болсон байна.

Эх сурвалж: BloombergTV.mn

МХБ: Канадын компанийн үнэт цаасыг III ангилалд бүртгэлээ

Торонтогийн Хөрөнгийн биржид бүртгэлтэй компанийн 1.2 сая канад долларын үнийн дүн бүхий дөрвөн сая хүртэлх ширхэг үнэт цаасыг Монголын Хөрөнгийн биржийн III ангилалд бүртгэсэн байна. Цаашид тэрхүү компанийн Монголын Хөрөнгийн биржид үнэт цаасаа давхар бүртгүүлж, үнэт цаасаа нийтэд санал болгох хүсэлтийг Санхүүгийн зохицуулах хороо шалгаж дууссаны дараа олон нийтэд мэдээлнэ гэж Монголын Хөрөнгийн биржээс гаргасан мэдэгдэлд дурдсан байна. Одоогоор Монголын Хөрөнгийн бирж компанийн нэрийг албан ёсоор зарлаагүй байгаа юм. Гэхдээ Торонтогийн Хөрөнгийн биржид бүртгэлтэй “Erdene Resource Development” компани “ Монголын Хөрөнгийн биржид давхар бүртгүүлэхээр төлөвлөж байгаа, II улиралд багтаан үр дүн нь харагдана” гэж өмнө нь мэдээлж байв. Тус компани Монголд Баянхөндий, Алтан арроу, Алтан нар ордуудад хайгуул хийж байгаа бөгөөд “Хайгуулаас олборлолтын шат руу шилжиж байгаа” гэдгийг Гүйцэтгэх захирал Питер Акерли мэдэгдсэн юм. Түүнчлэн гол гурван ил уурхайд нэгдсэн боловсруулах үйлдвэр байгуулахаар төлөвлөж байгаа ажээ. Сүүлийн байдлаар Торонтогийн Хөрөнгийн биржид “Erdene Resource Development”-ийн хувьцааны ханш 1.33 хувиар буурч, 0.37 канад доллар болсон байна. Гуравдугаар сарын 19-ний өдрөөс хойш хувьцааны ханш нь ерөнхийдөө буурах хандлагатай байгаа юм.

Эх сурвалж: MSE.mn

“Хөх ган” ХК-ийн хувьцааны ханш нэг жилд 67.8 хувиар өсөв

2015 оноос хойш сул зогсолт хийгээд байгаа “Хөх ган” компани 2018 онд ДРИ болон агломерат үйлдвэрлэх төлөвлөгөөтэй байгаа талаараа мэдээллээ. “Хөх ган” компани 2008 онд IPO гаргаж, олон нийтээс 3.2 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлж байсан аж. Үүгээр жилд 30 мянган тонн ангижруулсан төмөр үйлдвэрлэх хүчин чадалтай ангижруулсан төмрийн үйлдвэр байгуулах төслийг Эрдэнэт хотод хэрэгжүүлсэн байна. Одоогоор тус компанийн 52.5 хувийг “Бэрэн” групп, 25.7 хувийг “Би Ди Сек” үнэт цаасны компани эзэмшиж байгаа ажээ. “Хөх ган” компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал энэ сарын 30-нд болох юм.

Тус компанийн хувьцааны ханш өнгөрсөн нэг жилийн хугацаанд 67.8 хувиар өсөж, 100 төгрөгт хүрээд байгаа юм. Ингэснээр зах зээлийн үнэлгээ нь 10.2 тэрбум төгрөгт хүрээд байна.

Эх сурвалж: BloombergTV.mn



“Баянгол зочид буудал” ХК-ийн ногдол ашиг тараалт 97 хувийн гүйцэтгэлтэй байна

Зочид буудлын салбарын 7.9 хувийг эзэлдэг “Баянгол зочид буудал” ХК 2017 онд төлөвлөгөөгөө давуулан биелүүлж, 6.4 тэрбум төгрөгийн борлуулалтын орлоготой ажилласан байна. Тус компани 2017 оны тавдугаар сард “JCI” байгууллагын зочдын 402 ор хоног, аравдугаар сард Бодибилдингийн Дэлхийн аваргын тэмцээний тамирчдын 1380 ор хоног зэргийг гэрээ хийснээр төлөвлөгөөний орлогыг биелүүлжээ. Мөн 2017 онд бүтээгдэхүүн, үйлчилгээнийхээ үнийг хямдруулж, төрлийг нь нэмэгдүүлсэн байна. Ингэснээр буудлын ор хоног өмнөх оноос 12 хувиар, рестораны хоол үйлдвэрлэлийн тоо долоо хувиар өсжээ. “Баянгол зочид буудал” компанийн хувьцааны ханш сүүлийн нэг жилд 12.5 хувиар буурсан бол одоо нэгж хувьцаа нь 35 мянган төгрөг болж зах зээлийн үнэлгээ нь 14.8 тэрбум төгрөг болоод байна. Тус компани нийт 22 удаа ногдол ашиг тараасан гэж Монголын Хөрөнгийн бирж мэдээллээ. 2017 онд нэгж хувьцаанд 355 төгрөгөөр тооцож, нийт 135.3 сая төгрөгийн ногдол ашиг зарлажээ. Үүнээс Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвөөр дамжуулан 13 хувийг, үлдсэн хувийг компаниар олгосон байна. Одоогоор ногдол ашиг тараалт 97 хувийн гүйцэтгэлтэй байгааг дээрх компани мэдээллээ.

Өнөөдрийн байдлаар Монгол Улсад олон улсын сүлжээ болон дотоодын хөрөнгө оруулалттай 532 зочид буудал үйл ажиллагаа явуулж байгаа талаар Үндэсний статистикийн хороо мэдээллээ. Энэ онд олон улсын сүлжээ хоёр зочид буудал нээлтээ хийх төлөвтэй байна.

Эх сурвалж: BloombergTv.mn

“Материал Импэкс” ХК: 2017 онд 492.98 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан

Монголын Хөрөнгийн биржийн II ангилалд бүртгэлтэй “Материал Импэкс” ХК 2017 онд 1392 чингэлэг ачааны импортын тээвэр хийсэн нь 2016 оноос 62 хувиар өссөн үзүүлэлт боллоо. Мөн 2017 онд 155 битүү вагонтой ачааны импортын тээвэр хийсэн нь өмнөх оноос тав дахин их дүн болж байгаа юм. Харин чингэлгийн экспорт нь 50 хувиар буурчээ. Чингэлгээр тээвэрлэсэн ачаа барааны 56 хувийг шинэ ба хуучин автомашин, автомашины сэлбэг, 38 хувийг хүнсний бүтээгдэхүүн эзэлсэн байна. 2016 онтой харьцуулахад шинэ ба хуучин автомашины тээвэрлэлт 45 хувиар өссөн үзүүлэлттэй байгааг “Материал Импэкс” компани мэдээллээ. Тус компани 2017 онд 492.98 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан нь жилийн дүнгээр 49 хувиар буурсан үзүүлэлт болсон байна. Үүнийг “Материал Импэкс” компани Засгийн газраас гурилын импортыг хориглосонтой холбон тайлбарлаж байгаа юм. Учир нь ОХУ-аас орж ирдэг гурилын вагон зогсож, түрээсийн агуулах нь суларсан байна.

Үүнээс гадна ОХУ Украин улсаас дамжин өнгөрөх тээврийг хориглосноос чихэр импортоор оруулж ирдэг компаниудын ачаа бараа эрс цөөрчээ. “Материал Импэкс” ХК 2017 оны цэвэр ашгаас нэгж хувьцаанд 10 төгрөг буюу нийт 13.68 сая төгрөгийг хувьцаа эзэмшигчдэдээ олгохоор болсон байна. Тус компани олон нийтэд нээлттэй болсон цагаас хойш нийт найман удаа ногдол ашгаа тарааж байгаа юм.

13 тэрбум төгрөгийн зах зээлийн үнэлгээтэй “Материал Импэкс” компанийн хувьцааны ханш сүүлийн нэг жилийн хугацаанд 10 гаруй хувиар өсөж, 9500 төгрөгт хүрээд байна.

Эх сурвалж: BloombergTv.mn



“Талх чихэр” ХК: 2017 онд 37.5 тонн бүтээгдэхүүн борлуулж, 36.4 тэрбум төгрөгийн орлоготой ажилласан

Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгч “Талх чихэр” компани 2018 онд тоног, төхөөрөмжөө шинэчилж, бүтээгдэхүүний нэр төрөл, үйлдвэрлэлийн хүчин чадлаа нэмэгдүүлэхээр болсноо мэдээллээ. Тус компани 2017 онд нийт 98 нэр төрлийн 37.5 тонн бүтээгдэхүүн борлуулж, 36.4 тэрбум төгрөгийн орлого олжээ. Орлогын хэмжээ өмнөх оноос 11.8 хувиар өссөн дүнтэй байна. Монголын Хөрөнгийн биржийн I ангилалд бүртгэлтэй “Талх чихэр” компани 2017 онд Итали улсын “СЕPI” компанийн 500 тонн гурил вакуум орчинд хадгалах, дамжуулах систем, мөн Чех улсын талхны иж бүрэн системийг тус тус ашиглалтад оруулсан байна. Тус компани 2017 оны ашгаас хувьцаа эзэмшигчдэдээ нэгж хувьцаандаа 170 төгрөг буюу нийт 174.03 сая төгрөг хуваарилахаар болжээ. Энэ нь цэвэр ашгийн 15.4 хувьтай тэнцэж байгаа юм. “Талх чихэр” компани олон нийтэд нээлттэй болсон цагаас хойш нийт 19 удаа ногдол ашгаа тарааж байгаа аж.

Эх сурвалж: BloombergTv.mn

АПУ ХК: 2017 онд 129.4 тэрбум төгрөгийн татвар төлж, 24.8 тэрбум төгрөгийн ашигтай ажилласан

Монголын Хөрөнгийн биржид бүртгэлтэй, зах зээлийн үнэлгээгээр тэргүүлэгч АПУ ХК 2017 онд 166 нэр төрлийн 97.2 сая литр бүтээгдэхүүн үйлдвэрлэсэн нь өмнөх оноос дөрвөн хувиар өссөн дүн болж байна. Мөн 129.4 тэрбум төгрөгийн татвар төлж, 24.8 тэрбум төгрөгийн ашигтай ажиллажээ.

“Heineken” компанитай нэгдэн, нийлснээр Зүүн Өмнөд Ази, Европын Холбоо, Хойд Америк руу зах зээлээ тэлэх боломжтой болсон гэж АПУ компани үзэж байгаа юм. Тус компанийн үйл ажиллагааны тайланд тусгаснаар олон улсын банк санхүүгийн байгууллагад 43.9 тэрбум төгрөгийн зээлийн хүүгийн эргэн төлөлт гүйцэтгэж, үйлдвэрлэлдээ 3.5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн байна. Түүнчлэн 2017 онд борлуулалтын тоо хэмжээ нь таван хувиар өсөж, 93 сая литр бүтээгдэхүүн борлуулжээ.

АПУ компанийн 2017 оны татвар төлөлт Монгол Улсын нэгдсэн төсвийн орлогын 1.6 хувь, татварын орлогын 2.1 хувь, онцгой албан татварын орлогын 18.3 хувь, нэмэгдсэн өртгийн албан татварын орлогын 1.3 хувийг дангаар бүрдүүлсэн байна.

Үүнээс гадна тус компани сүүний бизнес нэгжийг бие даасан ашгийн төв болгохоор зорьж өнгөрсөн онд сүүний бизнесээ тусгаарласан юм. Ингэснээр хөрөнгө оруулагчдад компанийн бизнес бүрийн үнэ цэнийг үнэлэхэд илүү тодорхой болох боломжтой болно гэж дүгнэсэн байна.

Түүнчлэн дэлхийн 170 гаруй улсад бүтээгдэхүүн нь худалдаалагддаг “Heineken” компанитай нэгдэн, нийлэх хэлцэл оны өмнө хийгдсэн юм. Хэлцлийн дүнд АПУ компани “Heineken”-ийн глобал шар айргийн “ноу хау”-ийг нэвтрүүлж, хэрэглэгчдэд хүргэх бүтээгдэхүүн, үйлчилгээгээ шинэ түвшинд хүргэхээр зорьж байгаа аж. Мөн үйлдвэрлэл, түгээлтийн сүлжээг өргөжүүлж, “Heineken”-ийн олон улсын худалдан авалтын боломжийг ашиглаж, үйлдвэрлэлийн өртөг, удирдлагын зардлыг бууруулж, борлуулалтаа нэмэгдүүлэх замаар ашиг орлогыг өсгөх тооцоолол хийжээ.

Үүнээс гадна цаашид компанийн зах зээлийн үнэлгээг өсгөж, ногдол ашгийн хуваарилалтыг нэмэгдүүлэхээр болсон байна. АПУ компани 2018 онд бүтээгдэхүүний нэр төрлөө өргөжүүлэн, нийт 218 нэр төрлийн 133.7 сая литр бүтээгдэхүүн үйлдвэрлэхээр төлөвлөдөг байгаа аж. Мөн 433.7 тэрбум төгрөгийн борлуулалт хийхээр төлөвлөсөн байна. Харин экспортын хувьд ОХУ, БНХАУ-ын ӨМӨЗО, Япон, БНСУ зэрэг улсад бүтээгдэхүүнээ худалдаалж байгаа юм.

Эх сурвалж: BloombergTv.mn

ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

Монголбанк гуравдугаар сард 734 кг алт худалдан авчээ

Монголбанк өнгөрөгч гуравдугаар сард иргэд, байгууллагаас нийт 734 кг алт худалдан авсан хэмээн мэдээллээ.

Тодруулбал тус банкны алт худалдан авалтын дүн 2018 оны эхний гурван сарын байдлаар 2.3 тоннд хүрч, өмнөх оны мөн үеэс 2.1 хувиар өсчээ. Энэ оны гуравдугаар сарын байдлаар Лондонгийн үнэт металлын захын ханш бага байснаас шалтгаалан 1 грамм алт худалдан авах Монголбанкны дундаж үнэ 101 мянга 822.30 төгрөг байлаа.

Монголбанкны алт худалдан авалтын дүн 2018 оны эхний улиралд харьцангуй бага байгаа нь шороон ордоос олборлолт хийдэг компаниудын ажил эхлээгүй, зөвхөн үндсэн ордын үйл ажиллагаа өрнөж буйтай холбоотой гэдгийг албаныхан хэлж байна.

Алт олборлолтын үйл ажиллагаа нь улирлын шинжтэй бөгөөд жилийн 8, 9, 10 дугаар сард хамгийн идэвхтэй олборлолт явагддаг байна.

Эх сурвалж: Montsame.mn

ЭХЯ: 2019 он гэхэд нийт эрчим хүчний 20 хувийг сэргээгдэх үүсвэр бүрдүүлнэ

Хоёрдугаар сард улсын хэмжээнд нийт 502.3 сая киловатт-цаг эрчим хүч үйлдвэрлэснээс долоо орчим хувийг нь сэргээгдэх эх үүсвэрийн үйлдвэрлэл бүрдүүлсэн байна. Монгол Улс тогтвортой хөгжлийн зорилтын үзэл баримтлалын хүрээнд 2020 он гэхэд эрчим хүчний хэрэгцээний 20 хувийг сэргээгдэх эх үүсвэрээр хангах зорилт тавьжээ. Ирэх онд энэ зорилгоо биелүүлэх боломжтой гэдгийг Эрчим хүчний бодлого төлөвлөлтийн газрын дарга онцолж байна. Эрчим хүчний яамны төлөөлөл Сайншандын салхин паркийн ажлын явцтай энэ сард танилцаж төлөвлөгөөний дагуу ажил үргэлжилж байна гэсэн дүгнэлт өгчээ. Хэдий тийм боловч сэргээгдэх эрчим хүчний нийлүүлэлт орчны нөхцөлөөс хамааран хэлбэлздэг тул хүчин чадал 200 мегаватт давбал системийн шингээх чадвар хүрэхгүй, зохицуулалт хийх шаардлагатай ажээ. Мөн хуулийн шинэчлэл хэрэгтэй гэдгийг Эрчим хүчний яамнаас мэдээлж байсан юм.

Төвийн бүсийн цахилгааны өртөг киловатт-цаг нь 145.8 төгрөг байгаа бол сэргээгдэх эрчим хүчний үнийг ам.доллараар тооцохоор хуульчилсан тул 2-3 дахин өндөр үнэтэй байна гэдгийг салбарынхан онцолж байна. Үүнтэй холбоотойгоор Эрчим хүчний яам үнийг төгрөгөөр тооцох хуулийн төслийг өргөн бариад байгаа аж. Түүнчлэн өрсөлдөөнийг дэмжиж үнийг бууруулах үүднээс үнийн доод хязгаарыг арилгана гэдгийг мэдээллээ.

Эх сурвалж: BloombergTvm.mn

БУСАД МЭДЭЭ



Монголбанк: Инфляц зорилтот 8 хувийн түвшинд тогтворжих төлөвтэй байна

Инфляц 2017 онд эрчимжиж байсан бол ирэх онуудад тогтворжихоор байгааг Монголбанкны инфляцын төлөв байдлын тайланд онцолж байна. Улирлын хандлага даган махны үнэ 2018 оны эхний хагаст нэмэгдэж, оны сүүлийн хагаст буурах хэдий ч 2017 оноос багаар хүнсний инфляцыг өсгөхөөр байгаа гэж онцолжээ. 2017 онд зарим татвар нэмэгдэж, хэрэглээний сагс шинэчлэгдсэн болон хатуу түлшний үнэ огцом нэмэгдсэн нөлөө 2018 оны I улирлаас эхлэн арилж, хүнсний бус инфляцыг бууруулах нөлөө үзүүлэхээр байна. Эдийн засгийн идэвхжлийг даган эрэлтийн шалтгаантай инфляц алгуур нэмэгдэхээр байгаа ч нэг удаагийн шинжтэй болон зарим нийлүүлэлтийн шалтгаантай инфляц буурч, цаашид инфляц зорилтот түвшний орчимд тогтворжих төлөвтэй байна. Сүүлийн жилүүдэд эдийн засгийн өсөлтөд голлох нөлөө үзүүлж байсан уул уурхайн бус салбаруудын өсөлт 2018 оноос саарах бол уул уурхайн салбарын өсөлт эрчимжихээр байгаа ажээ. 2018 онд худалдааны нөхцөл сайжирч, "Оюу Толгой"-ийн зэсийн баяжмал дахь металлын агууламж сэргэснээр уул уурхайн салбарын өсөлт өмнөх оноос нэмэгдэхээр байна.

Гадаадын шууд хөрөнгө оруулалт болон хувийн секторт олгох зээлийн хэмжээ нэмэгдэж, уул уурхайн бус салбарын үйлдвэрлэл үргэлжлэн идэвхжих хэдий ч өсөлт нь цаашид алгуур саарах төлөвтэй байна.

Эх сурвалж: BloombergTV.mn

МЭДЭГДЭЛ

Энэхүү хэвлэл /мэдээлэл, судалгаа/ нь "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК-ийн нэрийн өмнөөс зөвхөн өөрийн үйлчлүүлэгчид /харилцагчид/-д мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгдсэн ба энэ нь аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон аливаа санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Судалгаа /хэвлэл/-г бэлтгэх үеийн байдлаар түүнд агуулагдаж буй мэдээллийн үнэн бодит байдлыг хангах талаар шаардлагатай ажиллагааг хийсэн бөгөөд "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК нь мэдээллийн үнэн бодит байдалд баталгаа гаргахгүй. Энэхүү мэдэгдэлд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК хариуцлага хүлээхгүй болно.